

Career stages R1 to R4

АТБТ

Эрдмийн дэвшил замналын дөрвөн үе шат (R1-R4):

- **R1: Анхлан судлаач** (PhD хүртэл),
- **R2: Танигдсан судлаач** (докторын зэрэгтэй ч хараахан бүрэн бие даасан судлаач болж амжаагүй (докторын дараах), мөн ижил төвшний түршлага, үр чадвартай судлаачид),
- **R3: Батлагдсан судлаач** (бие даасан судлаач болон хөгжсөн),
- **R4: Тэргүүлэх судлаач** (өөрийн судалгааны салбар, чиглэлд тэргүүлж буй судлаачид).

Анхлан судлаач (R1) нь:

- Судалгааны ажлыг багшийн удирдлага дор явуулдаг;
- Судалгааны чиглэл, арга зүйн мэдлэг хөгжүүлэх зорилго, эрмэлзэлтэй;
- Судалгааны чиглэлийнхээ талаар сайн ойлголттой гэдгээ харуулсан;
- Удирдлага, зааврын дагуу өгөгдөл гаргах чадвартайгаа харуулсан;
- Нарийн төвөгтэй, шинэ санааг шүүмжит байдлаар шинжлэх, үнэлэх, нэгтгэх чадвартай;
- Судалгааны үр дүн, үнэ цэнийг судлаач хамт олондоо тайлбарлах чадвартай.

Танигдсан судлаач (R2) нь докторын зэрэг саяхан хамгаалсан (докторын дараах судлаач) эсвэл түүнтэй дүйцэх хэмжээний түршлага, чадвартай ч хараахан бүрэн бие даасан судлаач болж амжаагүй судлаачид. Танигдсан судлаач анхлан судлаачийн (R1) шинж чанар дээр нэмэх нь:

- Судалж буй чиглэлийнхээ талаар системтэй ойлголттой, тухайн салбартай холбоотой судалгааг чадварлагаар гүйцэтгэж чадахаа харуулсан;
- Судалгааны томоохон хөтөлбөрийг бүхлээр нь төсөөлөх, төлөвлөх, хэрэгжүүлэх, дасан зохицох чадвартайгаа харуулсан;
- Томоохон хэмжээний ажил, инновац, хэрэглээг хөгжүүлэх замаар мэдлэгийн хүрээг тэлсэн эх судалгааны ажилд хувь нэмрээ оруулсан. Энэ нь үндэсний болон олон улсын хэмжээнд сайн бүтээл, патент болон үнэлэгдсэн;
- Шинэ, нарийн төвөгтэй санааг шүүмжлэлтэй дүн шинжилгээ хийх, үнэлэх, нэгтгэх чадвартай;
- Эрдмийн үе тэнгийн хүрээлэлтэйгээ харилцаж чаддаг - судалгааны үр дүн, үнэ цэнийг чиглэлийн судлаачдын хүрээлэлд тайлбарлах чадвартай;
- Өөрийн ажил мэргэжлийн ахиц дэвшилд эзэн байж, удирдан залах, бодитой, хүрч болохуйц зорилтууд тавьж, хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах арга замыг тодорхойлж, хөгжүүлдэг;
- Эрдэм шинжилгээний хурал, семинарт хамтран өгүүлэл бичдэг.

Батлагдсан судлаач (R3) нь бие даасан түвшинд хүрч боловсорсон, танигдсан судлаачийн (R2) шинж чанаруудаас гадна:

- Өөрийн судалгааны чиглэлд хийсэн ажлаараа үнэлэгдсэн, нэр хүндтэй;
- Мэдлэг, судалгаа, хөгжүүлэлтийн хөгжилд хамтын ажиллагаа, хамтран ажилласнаар эерэг хувь нэмэр оруулсан;
- Судалгааны асуудлыг таньж, өөрийн мэргэжлийн хүрээнд зохих судалгааны арга зүй, шийдлийн чиглэлийг тодорхойлох чадвар;
- Судалгааны ажлыг хөтөлбөрийн дагуу урагш ахиулахуйц бие даасан судалгаа гүйцэтгэдэг;
- Хамтарсан судалгааны төслийг хамтран ажиллагсад болон төслийн түншүүдтэйгээ хамтран хэрэгжүүлэхэд манлайлах чадвартай;
- Голлох зохиогчоор эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэх, семинар, хурлын хэсгийг зохион байгуулах.

Тэргүүлэх судлаач (R4) нь өөрийн салбар, чиглэлээр тэргүүлэх судалгаа манлайлан гүйцэтгэдэг. Тэрээр судалгааны баг, бүлэг удирддаг эсвэл компанийн R&D лабораторийн эрхлэгч байна. "Тодорхой салбарт, онцгой тохиолдолд тэргүүлэх судлаачид ганцаараа судлаачаар ажилладаг хувь хүмүүс байж болно." Тэргүүлэх судлаач нь батлагдсан судлаачийн (R3) шинж чанараас гадна:

- Тухайн салбартаа олон улсад танигдсан нэр хүндтэй судлаач байна;
- Судалгаа шинжилгээний ажлыг танин мэдэх, гүйцэтгэлийг шүүн тунгаах чадвартай;
- Судалгааны салбартаа эсвэл олон салбарыг хамарсан шинжлэх ухааны томоохон хувь нэмэр (онцгой нээлт) оруулдаг;
- Судалгааны чиглэлийн ирээдүйн талаар стратегийн төсөөлөл боловсруулдаг;
- Өөрсдийн судалгааны ажлын үр дагавар, хэрэглээг өргөн хүрээнд харж чаддаг;
- Нөлөөлөл өндөртэй эрдэм шинжилгээний өгүүлэл, ном хэвлүүлж, танилцуулдаг, семинар, хурлын зохион байгуулах хороонд ажилладаг, үригдсан илтгэл тавьдаг.

The **European Framework for Research Careers** (2011) describes **four broad profiles** on the researchers' career development, which are independent of any particular sector (universities, research institutions, companies or NGOs):